

№	Боомтын нэр	Төрөл	Зэрэглэл	Горим	Хил залгаа орны мэдээлэл	
					улсын нэр	боомтын нэр
1	2	3	4	5	6	
1	Буянт-Ухаа	агаарын замын	олон улсын	байнгын		
2	Өлгий	агаарын замын	олон улсын	байнгын		
3	Чойбалсан	агаарын замын	олон улсын	байнгын		
4	Ховд	агаарын замын	олон улсын	байнгын		
5	Замын-Үүд	төмөр замын	олон улсын	байнгын	БНХАУ	Эрээн
6	Сүхбаатар	төмөр замын	олон улсын	байнгын	ОХУ	Наушки
7	Эрээнцав	төмөр замын	хоёр талын	байнгын	ОХУ	Соловьевск
8	Замын-Үүд	авто замын	олон улсын	байнгын	БНХАУ	Эрээн
9	Булган	авто замын	олон улсын	байнгын	БНХАУ	Такашикен
10	Бичигт	авто замын	олон улсын	байнгын	БНХАУ	Зүүн хатавч
11	Алтанбулаг	авто замын	олон улсын	байнгын	ОХУ	Хиагт
12	Цагааннуур	авто замын	олон улсын	байнгын	ОХУ	Ташантга
13	Ульхан	авто замын	хоёр талын	байнгын	ОХУ	Верхний Ульхан
14	Эрээнцав	авто замын	хоёр талын	байнгын	ОХУ	Соловьевск
15	Арцсурь	авто замын	хоёр талын	байнгын	ОХУ	Цаган-Толгой
16	Ханх	авто замын	хоёр талын	байнгын	ОХУ	Монды
17	Боршоо	авто замын	хоёр талын	байнгын	ОХУ	Хандгайт
18	Тэс	авто замын	хоёр талын	байнгын	ОХУ	Шара-Сурь
19	Хангий	авто замын	хоёр талын	байнгын	БНХАУ	Мандал
20	Гашуунсухайт	авто замын	хоёр талын	байнгын	БНХАУ	Ганцmod
21	Шивээхүрэн	авто замын	хоёр талын	байнгын	БНХАУ	Сэхээ
22	Хавирга	авто замын	хоёр талын	байнгын	БНХАУ	Ар хашаат
23	Баянхоншуу	авто замын	хоёр талын	байнгын	БНХАУ	Өвдаг
24	Сүмбэр	авто замын	хоёр талын	тур	БНХАУ	Рашаан
25	Даян	авто замын	хоёр талын	тур	БНХАУ	Хунышанзуй
26	Байтаг	авто замын	хоёр талын	тур	БНХАУ	Улиастай
27	Бургастай	авто замын	хоёр талын	тур	БНХАУ	Лаоемяо



## МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



**1800-1281**

## Гааль сонсож байна



Талархал



Гомдол



ACWJIT



Санал

## ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллээр хангах, сан бүрдүүлэх зорилгоор “Гаалийн лавлах-1281” нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, хувь эл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөлгөө огөх, сурталчилгаа хийх болон гаалийн зорчлол осирь чадлын сэргийлэл арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



Xeят

Сүхбаатар дүүрэг, "Их тойруу-81/1",

Улаанбаатар-14193, Монгол Улс


Ytac: (976-11) - 350049

Факс: (976-11) - 3500

E-mail: info@customs.r

Интернет: <http://www.customs.gov.mn>

# МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН БООМТ



# УЛААНБААТАР ХОТ 2019 ОН


## Монгол Улсын хилийн боомт

“Хилийн боомт” гэдэг нь улсын хилийг нийтээр хууль ёсоор нэвтрэх болохыг зөвшөөрсөн цэг гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл, улсын хилээр нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгсэл, мал амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хилийн мэргэжлийн хяналтын байгууллага хяналт шалгалт хийх, лабораторийн шинжилгээний үнэлэлт дүгнэлт гаргах зориулалтаар тусгайлан төхөөрөмжилсөн цогцолбор байгууламжийг хилийн боомт гэж ойлгож болно. Өргөн утгаараа усан зам, хуурай зам, агаарын зам, төмөр зам, хилийн дагуух том том хотууд бүхий экспорт, импортын төвлөрсөн газрууд байдаг. Манай улсын хувьд олон улсын хэмжээний боомттой харьцуулж үзэхэд тийм том боомт байхгүй.

Боомтоор нэвтрэх зорчигч тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүнтэй холбогдсон харилцааг гаалийн болон гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар мал амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг хүнсний болон ариун цэвэр, эрүүл мэнд, химийн хорт болон аюултай бодисын тухай, малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай зэрэг хуулиар тэрчлэн боомтоор нэвтрэх зорчигчдод Монгол улсын виз олгохтой холбогдсон харилцааг гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар тус тус зохицуулж байхаар Монгол улсын боомтын тухай хуулинд тодорхойлсон байгаа болно.

Монгол Улсын олон улсын гэрээ болон Засгийн газрын тогтоолд зааснаар манай улсын ОХУ-тай хиллэдэг хэсэгт 29, БНХАУ-тай хиллэдэг хэсэгт 13, агаарын замын 4, нийт 46 боомт ажиллахаас 14 нь олон улсын, 11 нь хоёр талын байнгын ажиллагаатай, 14 нь хоёр талын түр буюу улирлын ажиллагаатай, 2 нь дамжин өнгөрөх боомт байна (Энэ боомт нь зөвхөн ОХУ-тай хиллэдэг). Эдгээрийн 39 нь автозамын, 3 нь төмөр замын, 4 нь агаарын замын боомт юм.

## МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН БООМТЫН БАЙРШИЛ, 2017 ОН



- Олон улсын харилцааны боомт

- Хоёр талын байнгын ажиллагаатай боомт

- Түр ажиллагаатай хилийн боомт

- Гүний гаалийн байгууллага

- Одоо ажиллагаагүй боомт

- Дамжин өнгөрөх боомт

- ОХУ-тай хаах тохиролцоонд хүрээд байгаа хилийн боомт

- Олон улсын нисэх онгоцны буудал

1.“Олон улсын боомт (байнгын)” - ОХУ-тай - 5 боомт; БНХАУ-тай - 4 боомт;

2.“Олон улсын боомт (түр)” - БНХАУ-тай - 1 боомт;

3.“Хоёр талын боомт (байнгын)” - ОХУ-тай - 5 боомт; БНХАУ-тай - 2 боомт;

4.“Хоёр талын боомт (түр)” - БНХАУ-тай - 5 боомт;

5.Гүний гаалийн байгууллага (гаалийн салбар) - 13 боомт;

6.“Дамжин өнгөрөх боомт” - ОХУ-тай - 2 боомт;

7.“МУ, ОХУ-ын хамтарсан протоколоор хаахаар тохирсон боомт” - ОХУ-тай - 14 боомт;

8.“Одоогоор ажиллагаагүй байгаа боомт” - ОХУ-тай - 3 боомт;

9.“Агаарын замын хилийн боомт” - 4 боомт;

“Олон улсын боомт”-Монгол Улсын олон улсын гэрээний дагуу иргэний харьяаллыг үл харгалзан зорчигч, тээврийн

хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх боомт;

“Хоёр талын боомт”-хөрш оронтой боомтын асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу Монгол Улсын болон хөрш орны иргэн, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх боомт;

“Байнгын ажиллагаатай боомт” - Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар тогтоосон цагийн хуваарийн дагуу байнга ажиллах боомт;

“Түр ажиллагаатай боомт” - Боомтын асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар түр хугацаанд ажиллах боомт;

“Дамжин өнгөрөх боомт” (зөвхөн ОХУ-ын хувьд) - Дэд бүтэц, газарзүйн онцлогоос шалтгаалж нөгөө талын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч нэвтрэх зориулалттай боомт.